

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/267/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.НАРАНЦОГТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Лүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Лүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөр 12 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 89.9 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	193,238,071.10	194,117,516.08
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	97,964,632.30	143,337,340.99
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	97,964,632.30	143,337,340.99
31210	Төгрөг	97,964,632.30	143,337,340.99
31211	Төрийн сангийн харилцах	97,964,632.30	143,337,340.99
35	БАРАА МАТЕРИАЛ	95,273,438.80	50,780,175.09
35100	Түүхий эд материал	9,427,555.67	392,000.00
35110	Тусгай зориулалттай материал	8,308,255.67	0.00
35130	Эм боох материал	1,119,300.00	392,000.00
35400	Хангамжийн материал	85,845,883.13	50,388,175.09
35410	Бичиг хэргийн материал	953,200.00	156,200.00
35420	Аж ахуйн материал	49,699,867.10	0.00
35470	Бусад хангамжийн материал	35,192,816.03	50,231,975.09
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,538,773,657.67	1,646,077,756.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,538,773,657.67	1,646,077,756.27
39200	Биет хөрөнгө	1,517,687,457.67	1,625,195,271.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,532,595,135.00	1,567,246,798.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-171,697,474.65	-210,979,341.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	6,500,000.00	6,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-5,145,833.65	-5,470,833.67
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	219,736,079.50	278,896,485.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	-164,367,351.66	-151,543,861.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	206,860,400.30	223,580,229.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-127,355,385.47	-115,589,587.90
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,729,223.44	40,473,263.44
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,769,514.76	-13,759,678.70
39217	Ном	8,602,179.62	5,841,798.10
39300	Биет бус хөрөнгө	21,086,200.00	20,882,485.00
39301	Програм хангамж	4,686,999.00	4,686,999.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,970,799.00	-2,174,514.00
39303	Бусад биет бус хөрөнгө	18,370,000.00	18,370,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,732,011,728.77	1,840,195,272.35
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	12,545,060.00	11,819,060.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,545,060.00	11,819,060.00
41300	Өглөг	12,545,060.00	11,819,060.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	11,819,060.00	11,819,060.00
41360	Бусад өглөг	726,000.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	726,000.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,719,466,668.77	1,828,376,212.35
51	Засгийн газрын хувь оролцоо	1,719,466,668.77	1,828,376,212.35
51100	Засгийн газрын оруулсан капитал	471,634,870.59	471,634,870.59
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	471,634,870.59	471,634,870.59
51200	Хуримтлагдсан үр дүн	-27,203,369.25	81,706,174.33
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,747,100,035.02	-27,203,369.25
51220	Тайлант үеийн үр дүн	1,719,896,665.77	108,909,543.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,275,035,167.43	1,275,035,167.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,732,011,728.77	1,840,195,272.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,472,199,210.85	1,531,323,549.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,204,128.76	146,283,749.20
120	Нийтлэг татварын бус орлого	58,204,128.76	146,283,749.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		4,523,148.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		372,500.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,150,648.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	136,297,643.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	58,204,128.76	5,462,958.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,413,995,082.09	1,385,039,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,100,066,000.00	1,208,540,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,100,066,000.00	1,208,540,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	123,372,125.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	120,875,525.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,496,600.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	190,556,957.09	176,499,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	190,556,957.09	176,499,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,293,995,641.91	1,371,439,083.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,293,995,641.91	1,371,439,083.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,153,266,141.37	1,319,147,583.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	719,784,898.44	859,429,043.97
210101	Үндсэн цалин	515,506,259.14	568,973,582.22
210102	Нэмэгдэл	161,887,564.68	254,258,734.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	42,391,074.62	36,196,727.21
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,331,520.10	106,584,672.34
210201	Тэтгэврийн даатгал	61,108,634.43	72,935,115.82
210202	Тэтгэмжийн даатгал	7,557,855.30	8,594,009.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,133,166.57	6,846,907.70

210204	Ажилгүйдлийн даатгал	1,411,951.65	1,654,988.18
210205	Эрүүл мэндийн даатгал	14,119,912.15	16,553,650.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	166,369,863.00	174,619,300.00
210301	Гэрэл, цахилгаан	27,821,556.00	10,413,900.00
210302	Түлш, халаалт	138,548,307.00	164,205,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,592,512.00	2,760,381.52
210401	Бичиг хэрэг	198,500.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	1,832,120.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	149,160.00	0.00
210404	Ном, хэвлэл	0.00	2,760,381.52
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,412,732.00	0.00
2105	Нормативт зардал	117,117,850.00	68,363,650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	751,700.00
210502	Хоол, хүнс	117,117,850.00	67,611,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,500.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	71,500.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,953,700.00	7,687,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,636,600.00	372,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,317,100.00	7,315,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,394,030.15	98,703,035.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,231,198.00	22,315,773.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,639,420.00	12,296,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,523,412.15	64,090,762.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	140,729,552.25	52,291,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	139,729,552.25	51,411,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	51,411,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	59,404,300.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	59,438,700.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,886,552.25	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,000,000.00	880,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,000,000.00	880,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	176,853,784.91	159,884,465.49
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	50,974,921.91
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	50,974,921.91
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	176,853,784.91	108,909,543.58

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,413,995,082.09	1,389,562,948.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	4,523,148.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	4,523,148.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	4,523,148.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	4,523,148.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,409,088,367.44	1,385,039,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,100,066,000.00	1,208,540,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,100,066,000.00	1,208,540,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	123,372,125.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	120,875,525.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,496,600.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	190,556,957.09	176,499,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	190,556,957.09	176,499,300.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,264,772,660.14	1,306,332,639.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,264,772,660.14	1,306,332,639.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,068,831,160.14	1,253,315,139.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	720,621,679.92	859,429,043.97
210101	Үндсэн цалин	495,235,237.09	568,973,582.22
210102	Нэмэгдэл	182,235,237.09	254,258,734.54
210104	Урамшуулал	42,391,073.73	36,196,727.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,494,790.87	106,584,672.34
210201	Тэтгэврийн даатгал	61,706,306.75	72,935,115.82
210202	Тэтгэмжийн даатгал	7,215,929.84	8,594,009.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,752,601.83	6,846,907.70
210204	Ажилгүйдлийн даатгал	1,347,239.72	1,654,988.18
210205	Эрүүл мэндийн даатгал	13,472,712.73	16,553,650.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	154,283,800.00	174,619,300.00
210301	Гэрэл, цахилгаан	8,028,941.00	10,413,900.00
210302	Түлш, халаалт	146,254,859.00	164,205,400.00
2105	Нормативт зардал	70,552,850.00	67,611,950.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	70,442,850.00	67,611,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	0.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,813,700.00	7,687,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,496,600.00	372,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,317,100.00	7,315,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,511,929.00	36,382,673.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,762,029.00	24,151,173.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,749,900.00	12,231,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195,941,500.00	53,017,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	183,721,500.00	52,137,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,992,000.00	52,137,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	59,404,300.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	59,438,700.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,886,500.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	880,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	880,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	151,104,832.30	83,230,308.69
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	50,880,200.00	37,857,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,880,200.00	37,857,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	50,880,200.00	37,857,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	50,880,200.00	37,857,600.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-50,880,200.00	-37,857,600.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	100,224,632.30	45,372,708.69
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	97,964,632.30
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	97,964,632.30	143,337,340.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	471,634,870.59	1,275,035,167.43	-107,524,684.93	1,639,145,353.09
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	471,634,870.59	1,275,035,167.43	-107,524,684.93	1,639,145,353.09
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	56,398,885.22	56,398,885.22
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	471,634,870.59	1,275,035,167.43	-27,203,369.25	1,719,466,668.77
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	471,634,870.59	1,275,035,167.43	-27,203,369.25	1,719,466,668.77
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	471,634,870.59	1,275,035,167.43	-27,203,369.25	1,719,466,668.77
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	108,909,543.58	108,909,543.58
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	471,634,870.59	1,275,035,167.43	81,706,174.33	1,828,376,212.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,495,368,900.00	1,344,190,239.31	151,178,660.69	89.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,495,368,900.00	1,344,190,239.31	151,178,660.69	89.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,431,065,900.00	1,291,172,739.31	139,893,160.69	90.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	967,172,500.00	859,429,043.97	107,743,456.03	88.9
210101	Үндсэн цалин	655,673,900.00	568,973,582.22	86,700,317.78	86.8
210102	Нэмэгдэл	269,017,200.00	254,258,734.54	14,758,465.46	94.5
210104	Урамшуулал	42,481,400.00	36,196,727.21	6,284,672.79	85.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,396,200.00	106,584,672.34	14,811,527.66	87.8
210201	Тэтгэврийн даатгал	82,549,700.00	72,935,115.82	9,614,584.18	88.4
210202	Тэтгэмжийн даатгал	9,711,700.00	8,594,009.88	1,117,690.12	88.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,769,300.00	6,846,907.70	922,392.30	88.1
210204	Ажилгүйдлийн даатгал	1,942,100.00	1,654,988.18	287,111.82	85.2
210205	Эрүүл мэндийн даатгал	19,423,400.00	16,553,650.76	2,869,749.24	85.2
210301	Гэрэл, цахилгаан	10,413,900.00	10,413,900.00	0.00	100.0
210302	Түлш, халаалт	164,205,400.00	164,205,400.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	880,000.00	0.00	880,000.00	0.0
2105	Нормативт зардал	72,946,300.00	67,611,950.00	5,334,350.00	92.7

210502	Хоол, хүнс	72,946,300.00	67,611,950.00	5,334,350.00	92.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,650,900.00	7,687,500.00	2,963,400.00	72.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,496,600.00	372,500.00	2,124,100.00	14.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,154,300.00	7,315,000.00	839,300.00	89.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,400,700.00	74,240,273.00	8,160,427.00	90.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,169,200.00	62,008,773.00	8,160,427.00	88.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,231,500.00	12,231,500.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,303,000.00	52,137,500.00	12,165,500.00	81.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,303,000.00	52,137,500.00	12,165,500.00	81.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	64,303,000.00	52,137,500.00	12,165,500.00	81.1
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,499,368,900.00	1,389,562,948.00	109,805,952.00	92.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,224,905,900.00	1,208,540,500.00	16,365,400.00	98.7
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,224,905,900.00	1,208,540,500.00	16,365,400.00	98.7
320001	Орон нутгийн төсвөөс	176,499,300.00	176,499,300.00	0.00	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	4,523,148.00	-4,523,148.00	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,523,148.00	-4,523,148.00	
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	97,963,700.00	0.00	97,963,700.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0.00	97,964,632.30	-97,964,632.30	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0.00	143,337,340.99	-143,337,340.99	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Лүн сумын Ерөнхий боловсролын сургууль нь сургуулийн өмнөх насны болон сургуулийн насны хүүхдийг бие бялдар оюун ухаан нийгэмшихүйн хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Лүн сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оныг "Залуучуудын хөгжлийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 12 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 89,9 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус сургууль нь 48 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал,заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр *нөлөөтэй* байна.

2023 он 11 сард Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдаж, 92,8 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Лүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Лүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт *ороогүй* байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 108,183.5 мянган төгрөгөөр буюу 6,2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	97.964.6	143,337.3	45,372.7
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	95,273.4	50,780.1	-44,493.2
Үндсэн хөрөнгө	1,538,773.6	1,646,077.7	107,304.0
Нийт хөрөнгө	1,732,011.7	1,840,195.2	108,183.5
Өр төлбөр	12,545.0	11,819.0	-726.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,719,466.7	1,828,376.2	108,909.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,732,011.7	1,840,195.2	108,183.5

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 143,337.3 мянган төгрөг болж өмнөх оноос 45,372.7 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны төсвийн гүйцэтгэл орон тоо дутуу цалин, нэмэгдэл хэмнэсэнтэй холбоотой.

Бараа материал дансны үлдэгдэл 44,493.2 мянган төгрөгөөр буурсан нь сургуулийн захирлын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/25 тоот тушаалаар тусгай зориулалтын материалаас 5,232.4 мянган төгрөг, аж ахуйн материалаас 32,451.6 мянган төгрөг, бусад хангамжийн материалаас 12,879.1 мянган төгрөг нийт 50,563.2 мянган төгрөгийн материал актлан устгаснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө данс 107,304.0 мянган төгрөгөөр өссөн нь сургуулийн 100 жилийн ойн хүрээнд барилга байгууламжийг 34,651.6 мянган төгрөгийн капитал засвар хийсэн, машин тоног төхөөрөмж 22,870.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 31,215.9 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 16,744.0 мянган төгрөг нийт 105,481.6 мянган төгрөгийн хөрөнгө, аймгийн боловсролын газраас багш бүрийг компьютержуулах аяны хүрээнд 26 ширхэг 26,312.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, тавилга эд хогшил 4,504.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

Сумын ИТХ-н 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 04 тоот тогтоолоор машин тоног төхөөрөмж 23,879.2 мянган төгрөг, тавилга эд хогшил 23,000.1 мянган төгрөг, ном 2,760.4 мянган төгрөг нийт 49,639.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 11,819.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 726.0 мянган төгрөгөөр буурсан байна. Үүнд 11,819.0 мянган төгрөгийн халаалтын үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1.318.869.6 мянган төгрөг, орон нутгийн санхүүжилтээс 176,499.3 мянган төгрөг, нийт 1,495,368.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 1,495,368.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,495,368.9 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,495,368.9 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 568,344.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвөөс 233,275.4 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 1,503.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,344,190.2 төгрөг буюу 89,9 хувьтай байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,344,190.2 мянган төгрөг буюу 89,9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 151,178.6 мянган төгрөгөөр, үүнээс нормативт зардал 5,334.3 мянган төгрөгөөр, тэтгэврийн болон бусад даатгалын зардал 14,811.5 мянган төгрөгөөр, үндсэн цалингийн зардал 86,700.3 мянган төгрөгөөр, нэмэгдэл цалингийн зардал 14,758.4 мянган төгрөгөөр, урамшууллыг 6,284.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 8,160.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	71801-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	3,261.7	3,261.7		100%
2	80312 Сургалт семинар	1,630.9	1,630.9		100%
3	81605 Эрүүл мэндийг дэмжих	4,010.6	2,840.0	1,170.6	70,8%
4	81801 Үдийн цай хөтөлбөр	64,303.2	52,137.5	12,165.5	81,1%
5	81806 Дотуур байрны үйлчилгээ	106,384.4	89,300.4	17,083.9	83,9%
6	81816 Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх	34,111.4	34,063.6	47.8	99,9%
7	81823 Мэргэжил дээшлүүлэх	11,742.0	5,616.1	6,125.9	47,8%
8	81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	805.1	805.1		100%
9	81834 Боловсролын стандарт сургалтын үйл ажиллагаа	921,281.6	828,065.4	93,216.2	89,9%
10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	163,876.1	145,447.1	18,429.0	88,8%
11	81844 Төрөлжсөн сургалт	4,150.6	4,150.6		100%
12	81848 түрээсийг сурах бичиг	372.5	372.5		100%
13	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	176,499.3	176,499.3		100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Лүн сумын Ерөнхий боловсролын сургууль нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71801-80111	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал 100%	176,499.3	176,499.3
2	71801-80226	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Байр ашиглалтын үйлчилгээ 100%	3,261.7	3,261.7
3	71801-80312	2023-12-31	Сургалтын чанар сайжруулах	Сургалт семинар 100%	1,630.9	1,630.9
4	71801-81605	2023-12-31	Урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийг дэмжих 70,8%	4,010.6	2,840.0
5	71801-81801	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Үдийн цай хөтөлбөр 81,1%	64,303.2	52,137.5
6	71801-81806	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Дотуур байрны үйлчилгээ 83.9%	106,384.4	89,300.4
7	71801-81816	2023-12-31	Хүүхэд бүрийг компьютертой болгох	Хүүхдэд ээлтэй орчин 99,9%	34,111.4	34,063.6
8	71801-81823	2023-12-31	Мэргэшүүлэх	Мэргэжил дээшлүүлэх 47,8%	11,742.0	5,616.1
9	71801-81827	2023-12-31	Иргэн бүрийг бичиг үсэгтэй болгох	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр 100%	805.1	805.1
10	71801-81834	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Стандарт сургалтын үйл ажиллагаа 89,9%	921,281.6	828,065.4
11	71801-81835	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах 88,8%	163,876.1	145,447.1
12	71801-81844	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Төрөлжсөн сургалт 100%	4,150.6	4,150.6
13	71801-81848	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Түрээсийн сурах бичиг 100%	372.5	372.5

Үдийн цай хөтөлбөр, дотуур байрны үйлчилгээ арга хэмжээнүүд нь дутуу хэрэгжсэн нь орон тоо хэмнэсэн, хүүхдийн ирцтэй холбоотойгоор хэмнэгдсэн. Мэргэжил дээшлүүлэх арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь төлөвлөгөөт сургалт цуцлагдсанаас шалтгаалан дутуу хэрэгжсэн байна. Сургалтын хэвийн үйл ажиллагаа арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь томуу томуу төст өвчин ихэссэн, ЕБС цахимд шилжсэнтэй холбоотойгоор хүүхдийн ирц буурч хэмнэгдсэн.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Лүн сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд Хүүхэд сурах ээлтэй орчин бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд 20 ширхэг I rad, 2 ширхэг өнгөт принтер 2 ширхэг зөөврийн компьютер, 65 инчийн ухаалаг дэлгэц 1 ширхэг тус тус нийт 43,857.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авсан байна. Хүнсний материалаа тендер зарлаж шалгарсан Мөнхий Оюу Бадмаараг ХХК-с авдаг. Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг батлуулж зохих хууль, журмын дагуу гүйцэтгэсэн.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Лүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Мягмар, С.Дашдондог нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Лүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 02 дүгээр сарын 14-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,315,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 26,300.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 21,000.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэмнэж ажилласны үр дүнд ажиллагсад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Лүн сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорх хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 107,743.0 мянган төгрөгөөр
- Бүх төрлийн даатгалын зардлыг 14,811.5 мянган төгрөгөөр
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 8,160.4 мянган төгрөгөөр
- Нормативт зардлыг 5,334.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус Ерөнхий боловсролын сургууль нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 159 мэдээллийг байршуулсан байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3 “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн ба өмнөх аудитаар өгсөн алдаа зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Лүн сумын Ерөнхий боловсролын сургууль нь эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр

3 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад хэрэгжээгүй тул аудитын тайланд зөрчлөөр тусгав.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хувь хэрэгжүүлж байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,870.0	1	1,870.0	
Албан шаардлага	1	12,545.1	1	12,545.1	100%
Зөвлөмж	1		1		100%
Нийт дүн	3	14,415.1	3	14,415.1	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өр төлбөрийг санхүүгийн жилд багтаан барагдуулахал анхаарах

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,181.2 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс 1,181.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон.

5.1 Төлбөрийн акт

Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

2023 оны 4-р сард 1кг үхрийн махыг 12.3 мянган төгрөгөөр цэцэрлэгт нийлүүлж байсан бол сургуульд 1кг-г нь 15.0 мянган төгрөгөөр нийлүүлж үнэ зөрүүлсэн 1,181.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” заалтыг дагаж мөрдөөгүй, “Иж бүрэн байх” мэдэгдлийг хангахгүй байна. .

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.3 Зөвлөмж

Дээрх төлбөрийн акт болон албан шаардлагын биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цэцэрлэг, сургуульд нийлүүлсэн нэг байгууллагын барааны үнэ зөрүүтэй	1	1,181.2	1	1,181.2								
Дүн	1	1,181.2	1	1,181.2								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn